



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/142/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Алтай хот
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа
Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
Ахлах аудитор: Н.Гэрэлмаа
Утас: 99782918 Цахим хаяг: gerelmaan@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.23 № 63

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус газар нь Хантайшир уулын аймаг байгуулагдсаны 100 жилийн ой, байгууллагын 2023 оны ажлын төлөвлөгөөнд тусгасны дагуу аймгийн Засаг даргын 2023 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн А/300 дугаар захирамжаар аймгийн төвийн I бүсэд зөвшөөрөлгүй барьсан хашаа, амбаар, чингэлгийн доорх газрыг чөлөөлөх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Албадан чөлөөлөх шийдвэрийн дагуу нийт 93 байршилд 42393 м2 газар чөлөөлсөн.

Аудитын гол асуудал

Тайлант онд аймгийн хэмжээнд нийт 96 барилга байгууламж, бүтээн байгуулалтын ажил хэрэгжиж байгаагаас улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй барилга угсралт, их засварын 37, инженерийн шугам сүлжээний 25, зураг төслийн 4, авто замын 3, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр 3, бусад хувийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй 24 ажил байна.

Дээрх барилга байгууламжийн үе шатны ажлуудад 30 инженер техникийн ажилчид ажлын талбайд 105 удаа зохиогч болон захиалагчийн хяналтыг гүйцэтгэсэн байна.

0702000239

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд төсвийн захирагчийн 4 зорилтын хүрээнд 134 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 117 арга хэмжээ бүрэн, 17 арга хэмжээг 30.0-90.0 хувь буюу нийт дүнгээр 95.7 хувиар биелүүлж биелэлтийг аймгийн Засаг даргын Тамгын газар, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт хүргүүлсэн боловч дээд байгууллагаас ажлыг дүгнээгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мян.төгрөгөөр/

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	80,503.0	230,897.7
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	511,940.5	493,516.3
Нийт хөрөнгийн дүн	592,443.5	724,414.0
Нийт өр төлбөрийн дүн	209.8	11,281.1
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	592,233.7	713,132.9
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	592,443.5	724,414.0
Үйл ажиллагааны орлогын дүн	1,331,592.1	1,148,483.3
Үйл ажиллагааны зардлын дүн	762,587.2	1,039,684.2
Үйл ажиллагааны үр дүн	569,005.0	108,799.1
Үйл ажиллагааны бус үр дүн	5,519.1	
Үйл ажиллагааны нийт үр дүн	563,485.9	108,799.1
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	592,233.7	608,092.5
Тайлант оны үр дүн	15,858.7	108,799.1
Эцсийн үлдэгдэл	608,092.5	713,132.9
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	761,288.3	1,012,772.5
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	695,520.2	987,522.7
Үйл ажиллагааны ЦМГ	65,768.1	25,249.8
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(65,768.1)	(25,249.8)
Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0.0	0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,327,555.8	892,935.2
Урсгал зардал	1,175,259.3	892,935.2
Хөрөнгийн зардал	0.0	0.0
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	1,327,555.8	945,271.2
Улсын төсвөөс санхүүжих	1,327,555.8	853,992.0
Орон нутгийн төсвөөс санхүүжих		

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитын илрүүлэлт

Аудитаар 415,401.4 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Өмнөх үеийн үр дүнг 97,375.0 мянган төгрөгөөр зөрүүтэй,
- Үндсэн үйл ажиллагааны орлогыг тайланд 318,016.4 мянган төгрөгөөр илүү тусгаснаар урсгал үйл ажиллагааны санхүүжилт, нэмэлт санхүүжилтийн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

орлогыг дээрх дүнгээр дутуу тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 5,022.3 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 5,022.3 мянган төгрөгийн 5 зөрчил² илэрснээс, 2,006.8 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 3,015.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 2 албан шаардлага өгсөн.

5.1 Төлбөрийн акт

1. Ажиллагсдын амралтын цалинг үндсэн цалинтай давхардуулан 1,407.4 мянган төгрөгийг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно." гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Амралтын цалинг үндсэн цалинтай давхардуулан илүү олгосон цалинг төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

2. Ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчдын НДШ-д 144.0 мянган төгрөгийг үндэслэлгүйгээр илүү төлсөн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-т "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү төлсөн НДШ-ийг төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

3. Сахилгын шийтгэлтэй ажилтанд улирлын үр дүнгийн урамшуулал 455.4 мянган төгрөгийг олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.8-т "Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцно", Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.7-т "Төрийн жинхэнэ албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан өдрөөс хойш 1 жилийн дотор сахилгын шийтгэл хүлээгээгүй бол түүнийг сахилгын шийтгэлгүйд тооцно", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2 дугаар зүйлийн 2.7-т "Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Сахилгын шийтгэлтэй албан тушаалтанд олгосон урамшууллыг төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

Албан шаардлага

1. Удирдлагын буруутай шийдвэрээс болж ажлаас халагдсан ажилтанд шүүхийн шийдвэрээр 4,284.4 мянган төгрөгийн цалингийн нөхөн олговрыг олгосон бөгөөд буруутай этгээдээс нэхэмжлээгүй байгууллагын төсөв хохироосон нь Захиргааны ерөнхий хуулийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ.", Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1-т "Иргэнийг, эсхүл улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг төрийн албанд хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цалингийн нөхөн олговрыг буруутай этгээдээс нэхэмжлэн төсвийг хохиролгүй болгох арга хэмжээг авч ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

2. Тээвэр шатахууны зардлыг түүвэрлэн авч үзэхэд аймгийн төв дотор хяналт хийх ажлаар нийт 3,015.5 мянган төгрөгийг зарцуулсан нь шатахууны зарцуулалт өндөр, тооцооны хуудас бодитой бус байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй, ангилал, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/												
Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	2	415.4	-	-	2	415.4	2	415.4	-	-	-	-
Дүн	2	415.4	-	-	2	415.4	2	415.4	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/ Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	5	5.0	3	2.0	1	3.0	-	-	-	-	-	-
Дүн	5	5.0	3	2.0	1	3.0	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/ Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	1	-	-	-	-	-	-	-	1
Дүн	1	-	-	-	-	-	-	-	1
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	2	25.8	-	-	2	25.8	-	-	-
Дүн	2	25.8	-	-	2	25.8	-	-	-
-Нийт дүн	3	25.8	-	-	2	25.8	1	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1			1			
	НИЙТ		1			1			